

## ГАРЧИГ

|                                                                                                                                |   |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|
| 1. ХАБЭААлбаныажилтны үйл ажиллагааны үндсэн зорилго, чиглэл.....                                                              | 2 |
| 2. Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа.....                                                                                     | 2 |
| 3. Батлагдсан төлөвлөгөөт ажлын гүйцэтгэл, үүрэг даалгаврын биелэлтийн талаар: .....                                           | 2 |
| 3.1 Ажлын байран дахь анхан шатны, өдөр тутмын болон давтан зааварчилгаа өгөгдөж буй эсэхэд хяналт тавих талаар: .....         | 1 |
| 3.2 Байгууллагын гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн бэлэн байдал, нөхөн хангалтын талаар: .....                          | 3 |
| 3.3 Ажилчдыг ажлын өвөл, зуны улирлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангасан талаар зохион байгуулсан ажлын талаар ..... | 4 |
| 3.4 Засвар үйлчилгээнд ашиглагдаж байгаа багаж тоног төхөөрөмжид хяналт шалгалт:хийсэн талаар.....                             | 3 |
| 3.5 Хүнд хортой нөхцөлд ажиллагсадад хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүн олгуулах талаар хийсэн ажил: .....                 | 5 |
| 3.6 Сургалт зохион байгуулсан талаар:.....                                                                                     | 4 |
| 4. 2020 оны 1-р улирлын төлөвлөгөөний биелэлтийн нэгтгэл хүснэгт, төлөвлөгөөний биелэлтийн хувь: .....                         | 5 |
| 5. ХАБЭААлбаны ажилтны төлөвлөгөөт ажлыг хэрэгжүүлсэнээр хүрсэн үр дүн .....                                                   | 6 |
| 6. Бусад ажлын талаар .....                                                                                                    | 6 |
| 7.Цаашдын зорилт, хэрэгжүүлэх ажил.....                                                                                        | 6 |

## **1. ХАБЭААлбаны ажилтны үйл ажиллагааны үндсэн зорилго, чиглэл**

Хөдөлмөрэрхэлжбайгааажилтныэрүүлмэнд, хөдөлмөрийнчадварыгхэвээрхадгалжэрүүлажайорчиндхөдөлмөрлөхнөхцлөөрхангах, аюулослоосурьдчилансэргийлэхийнтулдбайгууллагын нийт ажиллагсад, албан хаагчид, инженер техникийн ажилтан /ИТА/ нарт Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй /ХАБЭА/, ариун цэврийн болон галын аюулгүй байдлын дүрэм зааврын шаардлагыг чанд мөрдүүлэх, аюулгүй ажиллах арга барил дадал эзэмшүүлэх, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх, мэдлэг олгох явдал юм.

Тайлант хугацаанд МУ-н 2008.05.22-нд батлагдсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль” болон түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмуудыг ажилдаа мөрдлөгө болгон ажиллаж байна.

Байгууллагын ажлын байрны эрсдлийг бууруулах, ажлын нөхцлийг сайжруулах, шаардлагатай багаж, хувцас хэрэглэлээр бүрэн хангах, хор саармагжуулах бүтээгдэхүүнээр хангаж ажиллах, ажиллагсадын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор төлөвлөгөө боловсруулан батлуулж ажиллаа.

## **2 Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

Зорилтын хүрээнд ажлын байрны анхан шатны болон давтан зааварчилгааг тухай бүр тогтмол өгч, ажлын байрны нөхцөлийг сайжруулах аюул осол тохиолдсон нөхцөлд яаралтай арга хэмжээ авах дадлага сургалтуудыг зохион байгуулах, гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл, эмийн сангийн бүрэн бүтэн байдлын ханган ажиллах чиглэлээр ажлаа төлөвлөн хэрэгжүүлэхээр ажилласан.

Батлагдсан төлөвлөгөөт ажил, хэрэгжүүлсэн үйл ажиллагааг дэлгэрүүлэн тайлагнаж байна.

## **3. Батлагдсан төлөвлөгөөт ажлын гүйцэтгэл, үүрэг даалгаврын биелэлтийн талаар:**

### **3.1 Ажлын байрны өдөр тутмын, анхан шатны болон давтан зааварчилгаа өгөгдөж буй эсэхэд хяналт тавих талаар:**

**Зорилт:** Ажиллагсдад ажилдаа гарахад нь шууд хариуцан ажилладаг алба, хэсгийн албан тушаалтан нарт хөдөлмөрийн аюулгүй байдлыг ханган ажиллах талаархи зааварчилгааг тогтмол өгч байгаа эсэхэд хяналт тавьж ажлын байранд гарч болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлнэ.

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:** Ажлын байрны анхан шатны болон өдөр тутмын, давтан зааварчилгын бүртгэлийн дэвтэрийг MNS-4969:2000 стандартын дагуу хариуцсан албан тушаалтнуудад зааварчилгаа өгч хүлээлгэн өгсөн ба хөтлөлтөнд байнга хяналт тавьж ажиллана.

**Хүрсэн үр дүн:** 2020 оны 1-р улиралд үйлдвэрлэлийн осол, авааргүй ажиллалаа.

**Хэрэгжилт:** ТҮА, ТТА-ны ахлах инженерүүд, Хэсгийн дарга нар, Засварын инженерүүд, Ерөнхий механикийн ажилчиддаа өгч байгаа өдөр тутмын зааварчилгааны дэвтрийг долоо хоногт 1 удаа шалган танилцаж шинээр ажилд орсон ажилтанд ажлын байран дахь анхан шатны зааварчилгаа өгч гарын үсэг зурж баталгаажуулан ажиллаа.

Тайлант хугацаанд ажлын байран дахь анхан шатны зааварчилгааг 14 хүнд, өдөр тутмын зааварчилгаагдавхардсан тоогоор 7772 ажилтанд, давтан зааварчилгааг 113 ажилтанд өгч гарын үсэг зуруулан баталгаажуулсан байна. Үүнээс:

а/ Өдөр тутмын зааварчилгааг давхардсан тоогоор

- Ерөнхий механикийн хэсэг - 415
- Засвар үйлчилгээний станц – 1216
- Жолооч – 6141 нийт 7772 хүнд

б/ Давтан зааварчилгааг 113 хүнд

в/ Ажлын байран дахь анхан шатны зааварчилгааг 14 хүнд нийт 7899 хүнд тус тус өгсөн байна.

**3.2 Гал унтраах багаж хэрэгсэлд үзлэг шалгалт хийж гал унтраагуурыг цэнэглүүлэх бусад багаж хэрэгсэлд шаардлагатай тохиолдолд нөхөн хангалт хийх:**

**Зорилт:** Гал түймэр, гамшиг ослын аюулаас урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд цаг алдалгүй арга хэмжээ авах нөхцлийг бий болгох

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:** Байгууллагын галын аюулгүй байдлыг хангах зорилгоор объектууд, хөдлөх бүрэлдэхүүний гал унтраах анхан шатны багаж хэрэгсэлд тогтмол үзлэг шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, нөхөн хангалт хийж бэлэн байдлыг хангуулана.

**Хүрсэн үр дүн:** Гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангуулж, хүртээмжийг нэмэгдүүлсэн.

**Хэрэгжилт:** Байгууллагын галын аюулгүй байдлыг хангах зорилгоор объектууд, хөдлөх бүрэлдэхүүний гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг 2 удаа үзлэг, шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулсан ба цэнэггүй

болсон галын 6 гал унраагуурыг цэнэглүүлсэн. Мөн угаалгын цехэд шинээр гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл байршуулан ажилласан. Автобусны бүрэн бүтэн байдал аюулгүй ажиллагааны үзлэг шалгалт тогтмол хийж шалгалтаар илэрсэн зөрчлийн талаар өглөөний шуурхайд мэдээлэл хийж, холбогдох албан тушаалтанд зөрчлийг арилгуулах үүрэг даалгавар өгч ажилласан.

**3.3. Ажилчдыг ажлын өвөл, зуны улирлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр цаг тухайд нь хангах ажлыг зохион байгуулж, чанар стандартыг шалгаж хяналт тавих**

**Зорилт:** Ажилчдыг аюулгүй ажиллах нөхцлөөр хангах, ажлын нөхцөлд тохирсон хувцас, хамгаалах хэрэгслэлээр хангахад оршино.

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:** Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн хангалт, ажилчдын ажлын хувцас авсан бүртгэл хөтлөлтөнд хяналт тавьж ажиллаж байна.

**Хэрэгжилт:** Шинээр ажилд орсон буюу ажлын хувцасны эдэлгээний хугацаа дууссан ажилчдад олгуулах, шалгагч нарт өвлийн хантааз олгуулах талаар нэгтгэлд шаардлага хүргүүлж захиалгыг өгч олгуулсан байна.

**3.4. Засвар үйлчилгээний ажилд хэрэглэгдэж буй багаж, тоног төхөөрөмжийн найдвартай аюулгүй ажиллагааг хангуулах ажлыг зохион байгуулах:**

**Зорилт:** Ажлын онцлогт тохирсон багаж хэрэгслээр цаг тухайд нь хангуулах аюулгүй байдлыг сайжруулах, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:** Тоног төхөөрөмжинд хийгдэх техникийн үзлэг үйлчилгээний графикийн дагуу үзлэг үйлчилгээ хийгдэж буй эсэх аюулгүй ажиллагаанд тогтмол үзлэг шалгалт хийж ажиллана.

**Хүрсэн үр дүн:** Багаж тоног төхөөрөмж бэлэн байдлыг хангуулан байгууллагын санхүүгийн боломжинд тулгуурлан дутагдалтай багаж хэрэгслээр ханган машин тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангуулан ажилласан.

**Хэрэгжилт:** ТТА-ны ахлах инженерийн баталсан тоног төхөөрөмжинд хийгдэх техникийн үзлэг үйлчилгээний графикийн дагуу үзлэг үйлчилгээ хийгдэж буй эсэхэд сар бүр ерөнхий механикийн хэсгийн тоног төхөөрөмжийн засварчин М.Балдан-Очиртой хамтарч токарийн суурь машин, наклад хадагч суурь машин, дугуй задлагч, точиль, суурин өрөмний найдвартай аюулгүй ажиллагаанд тогтмол үзлэг шалгалт хийж засварын станцын гар ажиллагаатай домкрат ажиллахгүй байгаа

зөрчил гарсныг шалгаад цаашид ажиллуулах боломжгүй талаар шаардлага бичиж техник технологийн хэлтэст хүргүүлсэн ба багаж тоног төхөөрөмжийг засварлуулан хэвийн ажиллагааг хангуулж ажиллаа

### **3.5 Хүнд хортой нөхцөлд ажиллагсадад хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүн олгуулж байх ажлын талаар:**

**Зорилт:** Хүнд, хортой нөхцөлд ажиллаж буй ажилчдын эрүүл, аюулгүй байдлыг хангах

**Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:** Хөдөлмөрийн хортой нөхцөлд ажиллагсдын нэрсийн жагсаалтыг шинэчлэн гаргаж батлуулах, хөдөлмөрийн хүнд хортой нөхцөлд ажиллаж байгаа ажилчдад хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүнийг нормын дагуу олгогдож байгаад тогтмол хяналт тавьж ажиллана.

**Хүрсэн үр дүн:** Хөдөлмөрийн хүнд хортой нөхцөлд ажиллаж буй ажилчдыг тухай бүр хор саармагжуулах бүтээгдэхүүнээр ханган ажилласан.

**Хэрэгжилт:** Захирлын тушаалын дагуу хөдөлмөрийн хортой нөхцөлд ажиллагсдын нэрсийн жагсаалтыг шинэчлэн батлуулж, хөдөлмөрийн хүнд хортой нөхцөлд ажиллаж байгаа ажилчидад хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүнийг нормын дагуу олгогдож байгаад тогтмол хяналт тавьж ажилласан.

2020онд 1-р улиралд хор саармагжуулах бүтээгдэхүүн хэрэглэх ажилчдын нормын сүү, аарц хэрэглэсэн хүний тоо

| Бааз        | Ажилчдын тоо /давхардсан/ | Нэг ажилтанд олгох хор саармагжуулах бүтээгдэхүүний өртөг /дунджаар/ | НИЙТ ӨРТӨГ           |
|-------------|---------------------------|----------------------------------------------------------------------|----------------------|
| 1-р бааз    | 3546                      | 500                                                                  | 1,773,000 төг        |
| <b>НИЙТ</b> | <b>3546</b>               | <b>500</b>                                                           | <b>1,773,000 төг</b> |

### **3.6 Сургалт зохион байгуулсан талаар:**

Сургалтын төлөвлөгөөний дагуу засварчдад багаж тоног төхөөрөмжтэй ажиллах аюулгүй ажиллагааг хангуулах талаар “Нарны зам” сургалтын төвтэй хамтран 1 цагийн сургалт явуулсан.

## **4. 2020 оны 1-р улирлын төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн хүснэгт, төлөвлөгөөний биелэлтийн хувь:**

Дээрх бүлэгт дэлгэрэнгүй тайлагнасан төлөвлөгөөт ажлын биелэлтийн хувийг хүснэгтээр нэгтгэж харуулав.

| № | Хийжгүйцэтгэх ажлууд                                                                                                                                    | Хариуцах эзэн                                               | Биелсэн эсэх | Хувь     |
|---|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------|--------------|----------|
| 1 | Ажлын байрны өдөрт тутмын, анхан шатны болон давтан зааварчилгаа өгөгдөж буй эсэхэд хяналт тавьж байх                                                   | Баазын ХАБЭАА                                               | Биелсэн      | 100 хувь |
| 2 | Гал унтраах багаж хэрэгсэлд үзлэг шалгалт хийж гал унтраагуурыг цэнэглүүлэх бусад багаж хэрэгсэлд шаардлагатай тохиолдолд нөхөн хангалт хийх            | Баазын ХАБЭАА, ТТ Алба, Ерөнхий механик, хангамжийн менежер | Биелсэн      | 100 хувь |
| 3 | Ажилчдыг ажлын өвөл, зуны улирлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэлээр цаг тухайд нь хангах ажлыг зохион байгуулж, чанар стандартыг шалгаж хяналт тавих | ХАБЭАА, хангамжийн менежер                                  | Биелсэн      | 100%     |
| 4 | Засвар үйлчилгээний ажилд хэрэглэгдэж буй багаж, тоног төхөөрөмжийн найдвартай аюулгүй ажиллагааг хангуулах ажлыг зохион байгуулах                      | ХАБЭАА ТТ Алба, Ерөнхий механик                             | Биелсэн      | 100 хувь |
| 5 | Хүнд хортой нөхцөлд ажиллагсдад хорсаармагжуулах хүнсний бүтээгдхүүн олгуул ах ажлыг зохион байгуулах, хяналт тавих                                     | Баазуудын ХАБЭАА, СБХ, Цайны газар                          | Биелсэн      | 100 хувь |
| 6 | Засварчдын мэргэжлийн ур чадвар, мэдлэг боловсролыг дээшлүүлэх, аюулгүй ажиллагааг хангуулах талаар сургалт зохион байгуулах                            | ХАБЭАА, "Нарны зам" сургалтын төв                           | Биелсэн      | 100 хувь |

2020 онд 1-р улиралд нийт үндсэн 6, дэд 15 ажил хийхээр төлөвлөснийг 100 % биелүүлэн ажиллав.

#### **5. ХАБЭАА-лбаны 1-р улирлын төлөвлөгөөт ажлыг хэрэгжүүлсэнээр хүрсэн үр дүн**

ХАБЭАА-лбаны авч хэрэгжүүлсэн ажлуудын үр дүнд учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэн, үйлдвэрийн осол авааргүй ажиллалаа.

Нийт төлөвлөсөн ажлыг 100 хувийн биелэлттэй хэрэгжүүлснийг дээрх тайлагнал болон нэгтгэсэн хүснэгтийн мэдээлэлд нэгтгэн үзүүлээ.

## **6. Бусад ажлын талаар**

Нэгтгэлийн захирлын тушаалаар Нийслэлийн ЗДТГ-т сайжруулсан түлшний хяналтын шуурхай штабт ажилласан.

1 дүгээр баазын хэмжээнд ариутгал халдваргүйжилтыг “Шинэ ариутгал” ХХК-тай хамтран бүх өрөө тасалгаа болон үйлчилгээнд гарч байгаа 282 автобус 4370 м2 талбайд ариутгал хийлгэлээ.

02-р сарын 25 нд сар шинийн баярын эргүүлийн хуваарийн дагуу хариуцлагатай эргүүл хийсэн.

02-р сарын 29 нд СБД-ийн 15-р хороонд 18-22 цагийн хооронд короновирусээс урьдчилан сэргийлэх эргүүл шалгалт хийсэн.

Хэлтсийн даргын өгсөн үүргийн дагуу гарашийн тэрэг тавигч, тэрэг тавигч нарт ажил сайжруулах шаардах бичиг өгч хариуцлагыг өндөржүүлэхталаар зөвлөгөө өгсөн.

Ариутгалын иж бүрэн хувцас болон нэг удаагийн 10 хувцас авчирч хүлээлгэн өгсөн.

Хуваарийн дагуу сард хийгдэх цэвэрлэгээнд тогтмол хяналт тавьж ажиллаж байна.

## **7. Цаашдын зорилт, хэрэгжүүлэх ажил**

Манай бааз нь цаашид Нэгтгэлийн хэлтэс албад болон мэргэжлийн байгууллагуудтай уялдаа холбоотой ажиллаж аваар осолгүй, ажлын байрны таатай орчинг бүрдүүлж ажиллах зорилт тавин ажиллаж байна.

ХЯНАСАН: БААЗЫН ДАРГА

Д.БАТБАЯР

ХАБЭААЛБАНЫ ДАРГА

П.ЦОГТ-ЭРДЭНЭ

ТАЙЛАН БИЧСЭН: ХАБЭААЖИЛТАН

Х.БУЯНДЭЛГЭР

1,2-р дугаар гражийн галын дотуур крантуудыг бүрэн ажиллагаатай болгосон.




Засварчдад “Нарны зам” сургалтын төвтэй хамтран сургалт зохион байгуулав.



Домакратанд засвар хийсэн байдал




1,2-р гараашийн дотор талд цэвэрлэгээ хийгдсэн байдал



Гадна орчинд цэвэрлэгээ хийсэн байдал





“Шинэ ариусгал” ХХК-тай хамтран ариутгал хийсэн байдал

